

## ИХ МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ЗҮТГЭЛТЭН ЕЛЮЙ ЧУЦАЙН ТОВЧ НАМТАРААС

*Н.Төмөр\**

Монгол гүрний төр, цэргийн зөвлөх сайд, Чингис хааны Есөн өрлөгийн нэг “Чу мэргэн”<sup>1</sup> болох Елюй Чуцай 1190 оны долдугаар сарын 24-нд Яньжинд /өнөөгийн Бээжин хот/ төрсөн. Елюй Чуцайн төрсөн он сар өдрийг түүхийн сурвалж бичигт дурдсан мөртлөө тэрээр чухам хаана төрсөн талаар ном сурвалжид бичсэн тодорхой зүйлгүй. Гэвч Елюй Чуцайг төрөхөд түүний эцэг Елюй Люй нь Алтан улсын баруун этгээдийн тэргүүн сайдын алба хашиж, ар гэр нь Алтан улсын нийслэл Яньжинд байсан зэрэг учир шалтгааныг үндэслэн Елюй Чуцайг Яньжинд төрсөн хэмээн түүхчид үзэж байна<sup>2</sup>.

Елюй Чуцайг 3 настай байхад эцэг нь нас барсан учир тэрээр өнчин хоцорч, төрсөн эхээр ном бичиг заалган, эрдэм боловсролтой болж, улмаар одон орон судлал, газарзүй, тооны ухаан зэргийг судалж, эмчлэх төлөгдөх аргыг сурч, шүлэг ном зохион бичдэг болжээ<sup>3</sup>.

1215 онд Монголын цэрэг Алтан улсын нийслэл Яньжин хотыг эзлэхэд Елюй Чуцай олзлогдож, Монголын төрд хүчин зүтгэх болсон юм. Чингис хаан түүнийг дэргэдээ байлган, зөвлөх түшмэлээр ажиллуулах болжээ. Елюй Чуцай өндөр албан тушаал эзлэн Чингис, Өгэдэй нарт Монголын төрийн хэрэг явдал болоод ялангуяа эзлэгдсэн орнуудыг хэрхэн захирах талаар чухал зөвлөгөөн өгч байсан бөгөөд Монголын хаан ч түүний зөвлөмж саналыг харгалздаг байсан билээ. Елюй Чуцай, Чингис, Өгэдэй хаадын дэргэд 30 шахам жил Монголын төрд зүтгэн 1234 оноос Их Монгол Улсын засгийн хэргийг ерөнхийлөн шийтгэх яамны ерөнхий сайдаар ажиллажээ<sup>4</sup>.

Чингис хааны 1219 онд Дундад Ази руу, 1224 онд Энэтхэг рүү хийсэн аян дайнд Елюй Чуцай оролцож, хааны дэргэд зөвлөгч болж явсан бөгөөд ажиглагдсан зүйлээ “Өрнө этгээд зорчсон тэмдэглэл” хэмээх зохиолдоо тодорхой бичсэн. Елюй Чуцай Их Монгол Улсын засгийн хэргийг ерөнхийлөн

\* Н.Төмөр - Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

шийтгэх яамны сайдаар ажиллахдаа эзлэгдсэн орны алба гувчуур, эдийн засаг, улс төр, соёл боловсролын холбогдол бүхий бүх асуудалд оролцож төрд чухал хэрэгтэй зөвөлгөө айлтгалыг хаанд дэвшүүлж, Их Монгол Улсын зарим хууль, дүрэм тогтооход идэвхтэй үүрэг гүйцэтгэж байсан юм. Энэ талаар түүний бичсэн “Номхон даяанчийн зохиолын эмхтгэл” гэдэг зохиолд туссан байдаг.

Елюй Чуцай 55 насалж, Өгэдэй хааны дараа Монголын төрийн хэргийг түр хамаарсан Туракина хатны 3-р онд буюу 1244 оны зургадугаар сарын 20-нд Хархорумд нас баржээ.<sup>5</sup>

Елюй Люй /1131-1191/. Елюй Чуцайн эцэг Елюй Люй нь Алтан улсын Ваньянь Юнь /1123-1181/ хааны үеэс Алтан улсын төрд алба хашиж, ялангуяа Ваньянь Цзинь хааны үед түүний нэр хүнд улам бүр өсөж, улмаар 1190 онд Алтан улсын баруун этгээдийн тэргүүн сайд болон дэвшжээ.<sup>6</sup>

Елюй Люйг бага байхад нь түүний эцэг Елюй Юйлу<sup>7</sup> нас барсан учир авга ах Елюй Дэюаньд өргүүлсэн. Елюй Дэюань нь тухайн үед Синпинцзнь хэмээх газрын захирагч байсан учир Елюй Люй нэлээд бололцоотой айлд өсөн, эрдэм ном заалгаж, ялангуяа одон орон судлал, зурхай зэрэг ухааныг сайн эзэмшсэн, кидан хэл, кидан бичиг сайн мэддэг болсон.<sup>8</sup> Чухам энэ л учир шалтгаанаар түүнд хожим хойно Улсын түүхийн хүрээлэн, Ёслолын яаманд алба хаших боломж бололцоог олгосон билээ. Елюй Люй Алтан улсын баруун этгээдийн тэргүүн сайдаар ажиллаж байгаад 1191 онд нас барсан.<sup>9</sup>

Елюй Люй нийт гурван гэргийтэй байсан бөгөөд Елюй Чуцайн төрсөн эх Янши нь түүний гурав дахь гэргий байв. Яншигийн түүх намтрын талаар сурвалж бичигт, түүнийг сурвалжилтан Ян Таний охин байсан гэж дурдсанаас өөр тодорхой зүйл бичээгүй.<sup>10</sup> Харин хятадын нэрт түүхч Ван Говэйн судалгааны дүгнэлтээс үзвэл, Янши 1232-1233 оны хооронд нас баржээ.<sup>11</sup>

Елюй Люй нь Елюй Чуцайгаас гадна бас хоёр хүүтэй байсан, энэ нь ахмад хөвгүүн Елюй Бяньцай, дунд хөвгүүн Елюй Шаньцай нар юм. Харин Елюй Чуцай түүний гурав дахь буюу отгон хөвгүүн нь байлаа.

Елюй Бяньцай /1171-1237/. Елюй Чуцайн том ах Елюй Бяньцай залуудаа чийрэг том биетэй, эрхий мэргэн харваач, 18 настай байхдаа улсын тэмцээнд оролцож шалгаран 3-р байранд орж байсан. Алтан улс, Сүн улстай /1201-1205/ дайтахад

Алтан улсын хаан Ваньянь Цзинь, Елюй Бяньцайг дайн байлдаанд идэвхитэй оролцон баатарлаг гавьяа байгуулсан хэмээн урамшуулан шагнаж, Цзижоу хотын заргачаар томилон ажиллуулжээ. Монголын цэрэг Алтан улс руу довтлох үед хааны ордныхон Елюй Бяньцайгаар цэргийн чухал боомт Дунпинфу хэмээх газрыг хамгаалуулж байсан.<sup>12</sup>

1232 онд Монголын цэрэг Алтан улсын нийслэл Бяньжин хотыг<sup>13</sup> бүслэн дайрахад Өгэдэй хааны зарлигаар /зөвшөөрлөөр/ Елюй Чуцай тус хотод амьдарч байсан өөрийн төрөл садангийн хүмүүсийг эрж хайх үед Алтан ордныхон Елюй Бяньцайг нэгэнт Чжэндин хэмээх газар руу нүүлгэн шилжүүлсэн байлаа. Елюй Бяньцай нүүж очсон хотноо амьдарч байгаад 1237 онд 67 настайдаа нас баржээ.<sup>14</sup>

Елюй Шаньцай /1172-1232/. Елюй Чуцайн хоёрдугаар ах Елюй Шаньцайг тэргүүн сайд агсаны хөвгүүн хэмээн хааны ордыхон анхааран үзэж, 1204-1210 онд Хэншуй хотын захирагч, Ланжоу хотын цэргийн захирагч зэрэг албан тушаалд томилон ажиллуулж байлаа. Дараа нь Елюй Шаньцай /1210-1215/ онд хаан хөвгүүний ёслолын хэрэг эрхлэх алба, хааны ордны оёдол эсгүүрийн хэрэг эрхлэх албаны эрхлэгчээр ажиллаж байгаад 1225 оноос Чжанхуацзюн хотын цэргийн жанжины туслах, Фэнсян хотын захирагчийн туслах зэрэг алба хашиж байжээ.<sup>15</sup>

1232 онд Өгэдэй хааны зарлигаар /зөвшөөрлөөр/ Елюй Чуцай Алтан улсын нийслэлд байсан садангийн хүмүүсээ эрж хайхад Елюй Шаньцай монголын цэргээс дайжин нийслэл хотыг орхин явахаас эрс татгалзаж, улмаар усанд живж амиа хорлосноор Алтан улсдаа үнэнч байснаа харуулан нас барсаныг мэдсэн. Тэгэхэд Елюй Шаньцай 61 настай байлаа<sup>16</sup>.

Елюй Чуцай нь Елюй Сюань, Елюй Чжу хоёр хөвгүүнтэй байсан гэж түүхийн сурвалж бичигт тэмдэглэсэн байдаг. Елюй Сюань нь Елюй Чуцайн ахмад хөвгүүн, түүний тухай мэдээ сэлт ховор хомс. Елюй Сюаний төрсөн эх Лянши нь Елюй Чуцайн авааль гэргий байсан боловч дайн дажинаас болж тэдний харилцаа холбоо олон жилээр тасарч, самуун үймээнээс дайжин зугтаж амьдарсаар Фанчэнь хэмээх газарт нас баржээ. Энэ үед Елюй Чуцай хоёр дахь гэргий Сушитэй нэгэнт амьдралаа холбосон байлаа. Суши нь хятадын нэрт яруу найрагч Су Дунпо /1037-1101/-гийн жичэнцэр охин /тавдугаар үеийн ач охин/<sup>17</sup>, Елюй Чуцайн хоёрдугаар хөвгүүн Елюй Чжугийн төрсөн эх, тэрээр

1243 онд нас баржээ<sup>18</sup>.

Елюй Сюанийг дүү Елюй Чжутай нь харьцуулахад эрдэм боловсрол муутай, төрд ямар нэгэн алба хашиж байгаагүй билээ. Елюй Сюаний нэр нөлөөгүй явсан нь төрсөн эцэг Елюй Чуцайгаас холдоод 20 гаруй жил болж, эцэг хүүгийн хоорондын харилцаа хөндийрч, эцгийнхээ хайр халамж, нэр нөлөөг хүртэж чадаагүйгээс шалтгаалсан байж болох юм. Алтан улс мөхөж, Хубилай хаан ширээнд суусаны дараа Елюй Сюань нас барсан тухай түүхийн сурвалж бичигт тэмдэглэсэн байдаг.<sup>19</sup>

Елюй Чжу /1221-1285/. Елюй Чуцайн бага хөвгүүн Елюй Чжу ах Елюй Сюанийг бодвол Юан улсын түүхэнд нэлээд нэр алдартай хүн, түүний шастир Юан улсын сударт байдаг, мөн Елюй Чуцайн “Номхон даяанчийн зохиолын эмхтгэл” зохиолд Елюй Чжугийн тухай дурдсан зүйл бас бий.<sup>20</sup> Чингис хааны Дундад Ази руу хийсэн дайны үед 1221 онд Елюй Чжу төржээ. Тэрээр Монголд өсөж, эцгийнхээ хажууд эрдэм соёлыг ихэд сурсан. Елюй Чуцайг нас барсаны дараа Елюй Чжу 23 настай байхад нь эцгийнхээ алба хашиж байсан Их Монгол Улсын засгийн хэргийг ерөнхийлөн шийтгэх яаманд ерөнхий сайдын туслахаар ажиллах болсон. Тэрээр 1258 онд Мөнх хааны өмнөд Сүн улсыг мөхөөх дайн тулаанд оролцож Сычуан мужийг байлдан эзлэхэд зориулсан нэлээд олон байлдааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлсэн билээ. Хубилай хаан ширээнд суусаны дараа Елюй Чжу Хубилайн талд орж ажиллахаар болж, хаан ч түүнийг баяртай хүлээн авчээ. 1261 онд Хубилай хаан зарлиг буулган Елюй Чжу-г Засгийн хэргийг ерөнхийлөн шийтгэх яамны зүүн этгээдийн тэргүүн сайдаар томилон ажиллуулжээ. 1276-1282 онд улсын түүхийг хянан бичих ажилд Елюй Чжу томилогдон ажиллаж байгаад 1282 онд Засгийн хэргийг ерөнхийлөн шийтгэх яамны зүүн этгээдийн тэргүүн сайдаар дахин томилогджээ. Харин удалгүй 1283 онд Дунпингийн ард иргэд үймээн самуун дэгдээсэн хэмээн худал мэдээлж айлтгасан зэрэг хэргээр түүнийг буруутган тэргүүн сайдаас огцруулсан. Елюй Чжу үүнээс хойш 2 жилийн дараа 65 настайдаа нас баржээ.<sup>21</sup>

Елюй Чжу нийт арван нэгэн хөвгүүнтэй байсаны дотор хамгийн нэр алдартай нь гуравдугаар хөвгүүн Елюй Силян байлаа. Елюй Чуцайн ач хүү буюу Елюй Чуцайн 3-р хөвгүүн Елюй Силян /1247-1327/ 1247онд Хархорумд төржээ. Елюй Силян багадаа

цовоо сэргэлэн, ой сайтай хүүхэд байлаа. Тэрээр 9 настайгаасаа эцэг Елюй Чжугай хамт Яньжин хотод 5 жил амьдрахдаа<sup>22</sup> Алтан улсын нэрт эрдэмтэн Чжао Ений шавь болж эрдэм ном заалгаж байв. Елюй Силян хичээл ном заалгаад 10 хоног болоогүй байхдаа биеэ дааж шүлэг бичиж чалдаг болсон хэмээн сурвалж бичигт дурджээ. Хубилай хаан ширээнд суусны дараа Елюй Силяны эцэг Елюй Чжу ганц биеэрээ Хубилайн дэргэд алба хаших болсон, харин Елюй Силян эхтэйгээ хамт Аригбөхийн цэрэгт барьцаалагдан Линьву, Ганжао зэрэг газруудаар тэнүүчлэн амьдарч байлаа.<sup>23</sup>

Хубилай хааны зарлигаар Елюй Силян 1263-1271 онд хааны ордны шадар цэрэг, бичээч зэрэг алба хашиж, 1271-1280 онд Ёслолын яам, Боловсон хүчний яам зэрэг яамны сайд хийж байгаад хөлний өвчнөөр чөлөөнд гарчээ. 20 гаруй жил сул чөлөөтэй суусан Елюй Силян 1309 оноос Хайсан-Хүлэг хааны зарлигаар улсын түүх бичих ажилд дайчлагдаж, 1327 онд 81 настайдаа нас баржээ.<sup>24</sup>

#### ТАЙЛБАР, ЗҮҮЛТ

1. Монголын нууц товчоо. УБ. 1997; Н.Ишжамц. Монголд нэгдсэн төр байгуулагдаж феодализм бүрэлдэн тогтсон нь. УБ. 1974.
2. Алтан улсын судар, 9-р дэвтэр; Су Тяньцзюе. Юан төрийн нэрт түшмэдийн хэргийн товч /Юаньчао минчэнь шилуе/, 5-р дэвтэр. Су Тяньцзюе. 1294-1352 оны хооронд амьдарч байсан. Тэрээр Юан улсын төрд алба хашиж байгаад Тогоонтөмөр хааны үед 1352 онд Улаан алчууртны бослогыг дарахад дайчлагдаж, дайн байлдааны явцад өвчнөөр нас барсан. Түүний эцэг Су Чжидао /1261-1320/ нэг хэсэг Хархорумд алба хашиж байжээ. Хятадын түүхийн их толь / Чжунго лиши да цзыдянь/, Шанхай, 1986; Ту Ци. Монголын түүхийн тэмдэглэл /Мэн-у-эр шици/, 48-р дэвтэр; Л.Жамсран. Монголын түүхийн бага нэвтэрхий толь. 1-р боть. УБ. 1998.
3. Юан улсын судар, 146-р дэвтэр.
4. Монголын нэвтэрхий толь, 1-р боть, УБ, 2000; БНМАУ-ын түүх, 1-р боть, УБ, 1966 зэрэг номонд Елюй Чуцайг 1234 онд Их Монгол улсын засгийн хэргийг ерөнхийлөн шийтгэх яамны сайдаар томилсон гэж бичсэн байхад Юан улсын судар, 146-р дэвтэр; Ли Дунфан. Юан улсын тухай нарийн өгүүлэх нь /Сишо Юаньчао/, доод дэвтэр, Тайбэй, 1966; Л.Жамсран. Монголын түүхийн бага нэвтэрхий толь, 1-р боть, УБ, 1988 зэрэг номонд Елюй Чуцай 1231 оноос сайдаар томилогдсон хэмээн тэмдэглэжээ.
5. Юан улсын судар, 146-р дэвтэр; Су Тяньцзюе. Юан төрийн нэрт түшмэдийн хэргийн товч /Юаньчао минчэнь шилуе/, 5-р дэвтэр; Ту

- Цзи. Монголын түүхийн тэмдэглэл /Мэн-у-эр шицзи/, 48-р дэвтэр.
6. Юан улсын судар, 146-р дэвтэр; Алтан улсын судар, 9-р дэвтэр.
  7. Елюй Люин төрсөн эцэг Елюй Юйлугийн талаар түүхийн сурвалж бичигт тодорхой тэмдэглэсэн зүйлгүй, зөвхөн түүний нэрийг л дурдсан төдий байдаг. Алтан улсын судар, 9, 95-р дэвтэр.
  8. Алтан улсын судар, 95-р дэвтэр; Су Тяньцзюе. Төр улсын зохиолын төрөл анги /Гочао вэньлэй/, 57-р дэвтэр.
  9. Алтан улсын судар, 9, 95-р дэвтэр; Су Тяньцзюе. Төр улсын зохиолын төрөл анги /Гочао вэньлэй/, 57-р дэвтэр.
  10. Су Тяньцзюе. Төр улсын зохиолын төрөл анги /Гочао вэньлэй/, 57-р дэвтэр.
  11. Ван Говэй. Елюй Вэньчжэн гүнгийн намтрын он дараалал /Елюй Вэньчжэн гүн няньцу/. Ван Говэй 1877-1927 оны хооронд амьдарч байсан хятадын нэрт түүхч, философич. /Нийгмийн шинжлэх ухааны товч толь /Цзяньмин шехуй кэсюе цзыдянь /, Шанхай, 1985./
  12. Ишань ноёны зохиолын эмхтгэл /Ишань сяньшэн вэньцзи/, 27-р дэвтэр. Ишань бол Юань Хаовэний бичгийн нэр, тэрээр 1190-1257 оны хооронд амьдарч, Алтан улсын төрд алба хашиж байсан түшмэл, яруу найрагч /Хятадын түүхийн их толь /Чжунго лиши да цзыдянь /, Шанхай, 1986/.
  13. Бяньжин / өнөөгийн Кэфэн хот/ 1214-1233 онд Алтан улсын нийслэл байсан, 1234 онд Монголын цэрэгт эзлэгдсэн.
  14. Н.Ц. Мункуев. Китайский источник о первых монгольских ханах, Москва, 1965; Ишань ноёны зохиолын эмхтгэл /Ишань сяньшэн вэньцзи/, 27-р дэвтэр.
  15. Ишань ноёны зохиолын эмхтгэл /Ишань сяньшэн вэньцзи/, 26-р дэвтэр.
  16. Н.Ц. Мункуев. Китайский источник о первых монгольских ханах, Москва, 1965; Ишань ноёны зохиолын эмхтгэл /Ишань сяньшэн вэньцзи/, 26-р дэвтэр.
  17. Ж.Раднаабазар. Ургийн бичиг.
  18. Су Тяньцзюе. Төр улсын зохиолын төрөл анги /Гочао вэньлэй /, 57-р дэвтэр.
  19. Мөн тэнд.
  20. Юан улсын судар, 145-р дэвтэр; Елюй Чушай. Номхон даяанчийн зохиолын эмхтгэл /Чжанжан цзюйши вэньцзи /, 4-р дэвтэр.
  21. Юан улсын судар, 146-р дэвтэр, Хятадын түүхийн их толь /Чжунго лиши да цзыдянь /, Шанхай, 1986.
  22. Мөнх хааны зарлигаар Елюй Чжу энэ хугацаанд Яньжинд алба хааж байсан. Юан улсын судар, 180-р дэвтэр.
  23. Юан улсын судар, 180-р дэвтэр; Хятадын түүхийн их толь /Чжунго лиши да цзыдянь /, Шанхай, 1986.
  24. Мөн тэнд.